



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/332

Чингис хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118, 154, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41, 43, 46, 51 дүгээр тушаал, Аймгийн Онцгой комиссын 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай

2. Коронавируст халдварт (ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тархалтад хийсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Улаанбаатар хот, аймаг хооронд хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэнд, хүнс, бараа, түлш шатахууны тээвэр, дэд бүтцийн чиглэлээр хийгдэх хөдөлгөөн, албан томилолт, буяны үйл ажиллагаа)-аас бусад орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 24:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарлаж, холбогдох дүрэм, журмыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Коронавируст халдварт (ковид-19)-ын батлагдсан тохиолдлын хавьтал болон гэрийн тусгаарлалтад байгаа иргэд Улсын Онцгой комиссын даргын 43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж тусгаарлалтын дэглэм зөрчихгүй гэрээс гарахгүй байхыг нийт иргэдэд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Батсайхан), сумын Засаг дарга нарт даалгасугай

231011729

2.

4. Төрийн байгууллага 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл богиносгосон цагаар (09:00-12:00, 14:00-16:00) ажиллуулахыг төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, бодит байдлыг бүх шатны боловсролын байгууллагын цахим сүлжээг ашиглан сурталчлан ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (С.Мөнхцэцэг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Энх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

6. Эрсдэлт бүлгийн хүн амын хяналтыг сайжруулж, судалгааг гарган байнгын хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

7. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс тусгай журмаар (орон нутгийн иргэдэд) ажиллуулж, рашаан сувилал, аялал зугаалга (Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамт олон), олон нийтийг хамарсан найр, цайллага, овоо тахилга, морин уралдаалгийн үйл ажиллагааг дээрх хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), сумын Засаг дарга нарт даалгасугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ